



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

“Сар шинийн баяр”-ын өдрийг тохиолдуулан
дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх
ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Чингэлтэй ахмадууд-2028” арга хэмжээ батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын уламжлалт “Сар шинийн баярын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч	Ж.Тамир	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд	Б.Нацагдорж	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
	Т.Батцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Э.Энхсүвд	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	П.Төвсанаа	Дүүргийн Ахмадын хорооны дарга
	Б.Ерөө	Дүүргийн 7 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

2. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ